III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

БАТЛАВ.
ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С. ТӨМӨРХҮҮ

"NEW NORM" ШИНЭ НОРМ ДЭЭР СУУРИЛСАН МЭДЭЭЛЛИЙН САН, "POPULAR NORM" ӨРГӨН ХЭРЭГЛЭЭНИЙ НОРМЫН САН ХӨГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ДААЛГАВАР

2025 оны 06 дугаар сарын 09-ны өдөр Дугаар 05/2025 Улаанбаатар хот

1.	Төсөл боловсруулах үндэслэл	- Барилгын тухай хуулийн 34.1.2 дугаар заалт, - Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо"; - "Барилга байгууламжийн норм, нормативын сан"-ийн үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөний 53.4 дугаарт батлагдсан
2.	Төслөөр шийдвэрлэх асуудлууд	Шинэчлэн боловсруулж буй "Барилга, сантехник, цахилгаан, холбоо дохиолол, засварын ажлын төсвийн суурь норм"-уудыг программд оруулж хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай засвар өөрчлөлтүүдийг хийх, өгөгдлийн санг ОХУ-ын нормын суурь баазтай тулгаж боловсруулалтын алдааг засварлах, цаашид хөгжүүлэлт хийхэд шаардлагатай мэдээллийн санг бүрдүүлэх, хуучин нормтой харьцуулан судалгаа шинжилгээ хийж төсвийн өөрчлөлтийг тооцох, өргөн хэрэглээний материал, машин механизм, ажилбаруудын жагсаалтыг гарган шинэчлэгдсэн үнэ тарифыг оруулдаг холболтын программтай болно. Ингэснээр барилга байгууламжийн тосовт ортгийн тооцоог шинэчилсэн норм дүрмийн дагуу хийх суурь баазыг бодитой нэвтрүүлэх боломж бүрдэнэ.
3.	Төслийн бүрдэл	ӨГӨГДЛИЙН САН 1. Шинэчлэн боловсруулсан төсвийн суурь нормуудын 87 эмхэтгэлийг: - Үнэлгээний шифр; - Үнэлгээний нэр; - Үнэлгээний хэмжих нэгж; - Үнэлгээний дундаж зэрэг; - Үнэлгээний хүн цаг; - Машин механизм шифр; - Машин механизмын үнэлгээний нэр; - Машин механизмын үнэлгээний тоо; - Машинчийн цаг; - Материалын шифр; - Материалын нэр; Материалын орц; - Материалын хэмжих нэгж; - Бусад илэрсэн алдаа, давхцал, олон янзаар орчуулсан үг хэллэг, зөрүүтэй байдалд шинжилгээ хийж, "Барилга, сантехник, цахилгаан, холбоо дохиолол, засварын ажлын төсвийн суурь норм /87 эмхэтгэл/"-ын боловсруулагчтай хамтран оновчтой зөв сонголтыг хийж төсвийн программд

		өөрчлөлт хийх, засварлах ажлыг захиалагчтай яриилцаж бэлэн болгох. 2. ОХУ-ын нормын эх материалыг программд оруулж, 1:1 орчуулсан материалтай харьцуулж тулгах /гарсан засвар өөрчлөлтийг захиалагчтай зөвшилцөж бэлэн болгох; 3. Оновчтой нэр, тоон үзүүлэлтүүдийг сонгох программ хийх; /Зөвлөхүүд нэг утга санаатай нэршлийг олон янзаар орчуулсныг засварлах/ 4. Эх материалын дагуу орчуулсан нормуудыг программд оруулж хэрэглэгчдэд нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх; /мэргэжлийн үг хэллэг, утга найруулгын алдааг засварлах/ "NEW NORM" Шинэ норм дээр суурилсан мэдээллийн сангийн хүрээнд; 1. Шинэ нормын бүлэг, эмхэтгэл, шифр, ажилбарын нэршлээр хайлтын систем хийх; 2. Материал, машин механизм, тээвэр, тарифт цалингийн үнэ тариф, шифр өөрчлөх модуль хийх; 3. Нийт материалын түүвэр гаргах; /Шифр, нэр, жин, хэмжих нэгжийн давхцал, зөрүүтэй байдлын шинжилгээ хийх, орц норм бүрэн тусгагдсан эсэх/ 4. Нийт машин механизмын түүвэр гаргах; /Шифр, нэр, хүчин чадлын давхцал, зөрүүтэй байдлын шинжилгээ хийх, нэгж машин цагийн үнэлгээ орсон эсэх/ 5. Хөдөлмөр зарцуулалтын нормын үзүүлэлтүүдийг тулгах; /Ажлын бүтэц, хэмжих нэгж, хүн цагууд, ажилчдын дундаж зэрэг бүрэн тусгагдсан эсэх/ 6. Материал, машин механизм, тээвэр, тарифт цалингийн үнэ тарифын жагсаалт гаргаж норм тус бүрээр нэгжийн үнэлгээ гаргах. "POPULER NORM" өргөн хэрэглээний нормын сан хөгжүүлэх судалгааны программын хүрээнд: 1. Барилга, байгууламжийн төсөвт ортгийг тооцоход өргөн хэрэглэгдэж буй нормуудын жагсаалтыг гаргах, 2. Шинэ нормын өөрчлөлтийн сангаас дүйцүүлж сонгох хайлтын систем хийх; 3. Хэмжих нэгжийн зөрүүтэй байдлыг тохируулах модуль хийх; 4. Программд орсон байгаа материал, машин механизмын үнийг мөрдөж буй үнэтэй дүйцүүлэх ажлыг программаар хийх. Үүний дараа шинэ хуучин нормуудыг үнийн дүн, төсөвт өртгийн зөрүүг харьцуулах модуль хийх; 5. Өргөн хэрэглээний нормын үнэлгээ, технологийн дараалал, хуучин нормтой харьцуулсан байдлаар гүйцэтгэгч байгууллагаас судалгаа авч тайлан оруулах модуль хийх; 6. Эмхэтгэл бүрээр өргөн хэрэглээний нормуудын өөрчлөлт зөрүүний статистик, тайлан мэдээ гаргах.
4.	Төслийг хэрэгжүүлэх байгууллага	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, "Барилгын хөгжлийн төв" ТӨААҮГ.
5.	Төслийг гүйцэтгэх байгууллага	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулна.
6.	Төслийг боловсруулж дуусах хугацаа	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 3 сарын хугацааны дотор хийж гүйцэтгэнэ.

7.	Төсөлд шаардагдах хөрөнгийн хэмжээ	Урьдчилсан тооцоогоор 81,480,800 (наян нэгэн сая дөрвөн зуун наян мянга найман зуун) төгрөг. Санхүүжилтийн эх үүсвэр нь "Барилга байгууламжийн норм, нормативын сан"
8.	Онцгой нөхцөл	- "Барилга, сантехник, цахилгаан, холбоо дохиолол, засварын ажлын төсвийн суурь норм 87 эмхэтгэлийг хооронд нь уялдуулах; - Боловсруулж байгаа баримт бичгийн төсөл нь техникийн даалгаврын төслийн бүрдэлд тусгагдсан агуулгатай байхаас гадна боловсруулалтын явцад төслийг ойлгомжтой, эмх цэгцтэй нэмэлт мэдээлэл тусгагдахаар сайжруулалт хийх тохиолдолд захиалагчтай зөвшилцөж өөрчлөлт оруулах; - Холбогдох харьяа байгууллагуудаас санал авч, нэгтгэн, төсөлд тусгах; - Боловсруулагдаж байгаа баримт бичигтэй холбоотойгоор дагаж боловсруулах шаардлагатай баримт бичгийн жагсаалтыг ирүүлнэ. Жич: "New norm" шинэ норм дээр суурилсан мэдээллийн сан, "Popular norm" өргөн хэрэглээний нормын сан хөгжүүлэх ажлын 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 2024/20 дугаартай техникийн даалгаврыг хүчингүй болгов.

"NEW NORM" ШИНЭ НОРМ ДЭЭР СУУРИЛСАН МЭДЭЭЛЛИЙН САН, "POPULAR NORM" ӨРГӨН ХЭРЭГЛЭЭНИЙ НОРМЫН САН ХӨГЖҮҮЛЭХ АЖЛЫН УРЬДЧИЛСАН ТӨСӨВ

Д/д	Хийх ажлын нэр	Хөдөлмөр зарцуулалт, /хүн/өдөр/			Шаардагдах зардал /төгрөг/	Хянасан
		Хүн/ өдөр	Нэгж хүн өдрийн үнэлгээ /төгрөг/	Зөвлөх багт ажиллах хүний тоо		
1	Мэргэжлийн редакци, шүүмж /Орчуулгын нормын техникийн хэсэг, ажил, үнэлгээний нэршлийг хянан тохиолдуулж засварлах/	65	143,200	3	27,924,000	
2	Орос нормын тулгалт /Орос нормыг баазад оруулж, эцсийн байдлаар тулгалт хийх/	100	143,200	1	14,320,000	
3	Залруулга /Шифр, нэршлийн залруулга, нормын алдаануудыг засварлах/	68	143,200	2	19,475,200	
4	Өргөн хэрэглээний норм /Өргөн хэрэглээний ажил, үнэлгээнии жагсаалт гаргах судалгаа/	69	143,200	1	19,761,600	
	Нийт өртөг /төгрөг/				**81,480,800**	

Тайлбар: Үндэсний статистийн хорооны 2024 оны IV дүгээр улирлын байдлаар буюу тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тоогоор жигнэсэн нийт цалин хөлс болон тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тооны харьцаагаар тооцсон тооцоогоор гаргасан мэргэжилтэн өдрийн 143,200 төгрөгөөр тооцож гаргав.
https://www.1212.mn/mn/statistic/statcate/48171320/table-view/DT_NSO_0400_025V1

ХЯНАСАН:

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМНЫ САЛБАРЫН ХӨГЖИЛ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Ц.АДЪЯАБААТАР

ТУС ЯАМНЫ САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Ц.АРИУНСАНАА

ТУС ЯАМНЫ САЛБАРЫН ХӨГЖИЛ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ШИНЖЭЭЧ П.НЯМДАРЬ

ТУС ЯАМНЫ БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН

"New norm" шинэ норм дээр суурилсан мэдээллийн сан, "Popular norm" ерөн хэрэглээний нормын сан-тогтсуулах эрхлэн тонилгийн дүгнэлтэр

ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН		С.ДОЛЖИНСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:

"БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ		Т.ПҮРЭВХАТАН
ТУС ТӨВИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР		Б.ГАНБОЛД
ТУС ТӨВИЙН НОРМ, НОРМАТИВЫН ХЭЛТСИЙН ДАРГА		Д.АЛТАНХУЯГ
ТУС ТӨВИЙН НОРМ, НОРМАТИВЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН		О.ХӨВСГӨЛ